

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 05-р сарын 31

1. Тендер шалгаруулалтын нэр: **4 м3 багтаамжтай шанагатай автоачигч нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦТ/201803043**
2. Тендер шалгаруулалтын нэр: **Карьерын 50 тн даацтай өөрөө буулгагч автомашин нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦТ/201803047**

“Монголросцветмет” ХХК дээрхи 2 нэрийн барааг нийлүүлэх нээлттэй тендер шалгаруулалтыг давтан зарлаж байгаа бөгөөд эрх бүхий тендерт оролцогчдоос дээрхи барааг тус тусад нь нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэгүй авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000.00 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: *Сүүлийн 2 жилийн аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-иас багагүй байна*

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: *2016, 2017 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт*

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: **Шаардлагагүй.**

Тендерийн хамт *тендер тус бүрийн төсөвт өртгийн 2 хувьтай тэнцүү үнийн дүн бүхий* тендерийн баталгаа ирүүлэх бөгөөд үнийн дүнг тендерийн бичиг баримтын ТШӨХ-д зааж өгсөн.

Тендерийг *2018 оны 07-р сарын 02-ны өдрийн 15:00 цагаас* өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба тендерийг тендер тус бүрийн баримт бичигт буй урилгад заасан хугацаанд цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 305 тоот өрөө,

ҮҮХ-ийн ахлах мэргэжилтэн Б.Батсайхан, утас: 450060 + 138, 234

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ХХК